

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН АКТ**

2009 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 21/2009

Улаанбаатар хот

НЭГ.

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал

Барилга дүүргийн "Тэтэрх хөтлийн төв" - 90 хурдны  
(дээртэй хоёр давхар)

1.2. Ашиглагч захиалагч аж ахуйн нэгж, байгууллага

"Тэтэрх хөтлийн төв"

1.3. Ерөнхий ба туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага

"Хай тур" ХХК

1.4. Зураг төсөв боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага

"Экологидро" ХХК

1.5. БХБНААУ Товчин голтон

шийдвэрээр зохион байгуулсан 14 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулахад бэлэн болсон тухай захиалагч байгууллагын 2008 оны 8 сарын 21 өдрийн 63 тоот мэдэгдлийн дагуу 2008 оны 8 сарын 22-ны өдрөөс... өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл шинэтгэл, их засварын ажлын чанар, холбогдох акт, баримтуудыг танилцаад газар дээр нь шалган үзэв.

1.6. Энэхүү барилга байгууламжийг Б.Г.ширр 006/03 дугаартай зураг төслөөр 2007 оны 06 сараас барьж эхэлсэн ба 2008 оны 06 сарын 02 өдөр барьж дууссан байна.

ХОЁР.

2.1. Энэхүү "Тэтэрх хөтлийн төв"-ийн 90 хурдны  
сургалтын төвийн 8

барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалгаад ашиглалтанд оруулах тухай улсын комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Барилга байгууламжийн байнгын ашиглалтаар  
орлуулахад

2.2. Энэхүү барилга байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж

сургалтын төвийн

зориулалтаар ашиглахад "Барилга төв" гэж үзээд захиалагч (ашиглагч)

байгууллага болох "Тэтэрх хөтлийн төв"

мэдэлд 2009 оны 02 сарын 03 өдрөөс ашиглалтанд (үйлдвэрлэл үйлчилгээ, оршин суух зэрэг) оруулахыг зөвшөөрөв.

2.3. Улсын комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссийн акт, холбогдох баримтуудын эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад .... хоногийн дотор багтаан шилжүүлэх.

Захиалагч (ашиглагч) байгууллагад:

- А) "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар"- т уг барилга байгууламжийн холбогдох баримтуудыг ... хоногийн дотор багтаан бүртгүүлэх
- Б) Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх
- В) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгыг хэвийн ашиглаж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

2.4 Улсын комиссын акт. 3 хуудас, хуралдааны тэмдэглэл. 4 хуудас, улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт. 3 хуудас материал, барилга, байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.

Тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ!



**УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:**

Комиссын дарга

Ц.Баярбат

БХБНААҮТөв, Хот байгуулалт, зураг төслийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Доржсүрэн

БХБНААҮТөвийн  
БЧАБГазрын мэргэжилтэн

Гишүүд:

Л. Балдан-Очир

НМХГ-ын Барилгын техник  
хяналтын улсын ахлах байцаагч

Ё.Энхтүвшин

НМХГазрын Мэдээлэл холбооны  
хяналтын улсын ахлах байцаагч

И.Мянганбаяр

НМХГ-ын Эрчим хүчний хяналтын



/цахилгааны/ улсын байцаагч

  
Б.Мөнхсайхан

НМХГазрын Эрчим хүчний хяналтын  
/сантехникийн/ улсын байцаагч

  
Д.Жамсран

НМХГ-ын Хэмжил зүйн хяналтын  
улсын байцаагч

  
Ц.Батцэнгэл

НМХГ-ын Орчины эрүүл ахуйн  
хяналтын улсын байцаагч

  
Шинэ-Оргил


НМХГ-ын Байгал орчин газрын  
хяналтын улсын байцаагч

  
Н.Сэмжид


НМХГ-ын Авто зам газрын хяналтын  
улсын байцаагч

С.Баатарсүрэн

ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх  
газрын ахлах мэргэжилтэн

  
Ж.Ханипа

УТА-ын ШУТЗТБТөвийн зааварлагч,  
арга зүйч

  
Д.Оюунсүрэн

БГД-ийн Гэгээрэл хөгжил төвийн  
захирал

Ш.Отгонхүү "Хайтур" ХХК-ийн инженер



**УЛСЫН КОМИССЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ**

2008 оны 09 сарын 01 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Хэлэлцэх асуудал: Баянгол дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт Баянгол дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн захиалгаар, “Хайтур” ХХК-ийн барьсан, зорьтой 2 давхар, Гэгээрэл хөгжлийн төвийн барилгыг улсын комиссоор байнгын ашиглалтанд оруулах тухай.**

Улсын комисс доорх бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

**Оролцсон хүмүүс:**

Комиссын дарга	Ц.Баярбат	БХБНААҮТөв, Хот байгуулалт, зураг төслийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Доржсүрэн	БХБНААҮТөвийн БЧАБГазрын мэргэжилтэн
Гишүүд:	Л. Балдан-Очир	НМХГ-ын Барилгын техник хяналтын улсын ахлах байцаагч
	Ё.Энхтүвшин	НМХГазрын Мэдээлэл холбооны хяналтын улсын ахлах байцаагч
	И.Мянганбаяр	НМХГ-ын Эрчим хүчний хяналтын /цахилгааны/ улсын байцаагч
	Б.Мөнхсайхан	НМХГазрын Эрчим хүчний хяналтын /сантехникийн/ улсын байцаагч
	Д. Жамсран	НМХГ-ын Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч
	Ц.Батцэнгэл	НМХГ-ын Орчины эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
	Н.Шинэ-Оргил	НМХГ-ын Байгал орчин газрын хяналтын улсын байцаагч
	Н.Сэмжид	НМХГ-ын Авто зам газрын хяналтын улсын байцаагч
	С.Баатарсүрэн	ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн
	Ж.Ханипа	ҮТА-ын ШУТЗТБТөвийн зааварлагч, арга зүйч
	Оюунсүрэн	БГД-ийн Гэгээрэл хөгжил төвийн захирал
	Отгонхүү	“Хайтур” ХХК-ийн инженер

### **Хэлэлцсэн нь:**

Тус барилгын захиалагч Баянгол дүүргийн Гэгээрэл хөгжлийн төв нь зоорийн давхартай 2 давхар Гэгээрэл хөгжлийн төвийн барилгад улсын комисс ажиллуулах хүсэлтээ БХБНААҮТ-д 2008 оны 08-р сарын 26-ны өдрийн 63 тоот албан бичгээр хандсаны дагуу, техникийн комиссын акт, холбогдох баримт бичигтэй танилцаж, "Барилгын тухай" хуулийн 19 дугаар зүйл, БХБ-ын Сайдын 2007 оны 70-р тушаал болон 2006 оны 155-р тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах дүрэм"-ийн дагуу барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах улсын комиссын гишүүдийн ирц 80 хувь байгаа тул улсын комиссын үйл ажиллагааг эхлүүлэх саналтай байгаагаа комиссын нарийн бичиг, комиссын дарга, гишүүдэд танилцууллаа.

Улсын комиссыг БХБНААҮТ-ийн ХБЗТХ-ийн дарга бөгөөд улсын комиссын дарга Ц.Баярбат удирдав.

10.30 -д Улсын комиссын хурал эхэллээ.

### **Барилга байгууламжийн талаар:**

Нийслэлийн Засаг даргын 2004 оны 04-р сарын 15-ны өдрийн 164 тоот захирамжаар Баянгол дүүргийн Боловсрол хөгжлийн төвийн нэр дээр олгогдсон газарт тус газрын захиалгаар "Эл энд Эйч" ХХК-ийн гүйцэтгэсэн зураг төслийн дагуу ерөнхий гүйцэтгэгч "Хайтур" ХХКомпани барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Барилгын эзэлхүүн төлөвлөлт, хийц шийдлийн хувьд: 12,2 х 15,м-ийн хэмжээтэй талбайтай, Суурь угсармал блокон суурьтай, зүрхэвчтэй тоосгон өрлөгтэй ханатай, угсармал төмөр бетон нүхтэй хавтан хучилт, цутгамал шаттай, гадна хана 640 мм тоосгон өрлөг, гадуураа ... мм-ийн хөөсөнцөр дулаалгатай, ...мм-ийн тоосгон хана дээр шавардлага хийсэн байна. Архитектур төлөвлөлтийн хувьд зоорийн давхартаа авто машины дулаан зогсоолтой, нэг, хоёр давхартаа худалдаа үйлчилгээний заалтай барилга юм. "Экогеогидро" ХХК-ийн боловсруулсан 427 дугаартай инженер геологийн дүгнэлттэй. 2008 оны 06-р сарын 11-ний өдөр техникийн комисс ажилласан. Техникийн комиссын актын дугаар 12/08 болно.

Хурлыг эхлүүлж Улсын комиссын дарга Ц.Баярбат үг хэлж, өмнө ажилласан техникийн комиссын үүрэг даалгаварын биелэлттэй танилцаж, өөрсдийн санал бодлоо хэлэхийг гишүүдэд үүрэг болголоо.

Техникийн комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаварын биелэлт болон барилгын техникийн баримт бичиг, барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй танилцсаны дараа гишүүд санал дүгнэлтдээ хамтатган хэлэхээр шийдвэрлэлээ.

### **Улсын комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар:**

**Л. Балдан-Очир** - 1. Барилгын хаяавч бетоны дээгүүр дахин өнгөлгөө хийж өгөх. (зүүн хойд булан өргөсгөх)

2. Техникийн давхрын шавардлага гүйцээх, шалны өнгөлгөө хийх.

3. ОО-ийн өрөөнд тусгаарлах хана хийж өгөх.

4. Шатны хайсанд босоо тулаас хийж өгөх.

5. Давхар дундын шатны хонгилын цонхонд решётка хийж өгөх.

6. Барилгын ажлын журналын бөглөлтийг гүйцээж баталгаажуулах.

7. Гүйцэтгэлийн зураг хийж баталгаажуулах.

8. Суурийн ус нэвчилтийг зогсоож, зүүн хойд талын булангийн тогтсон усыг зайлуулах арга хэмжээ авах.

Протоколын биелэлтээр хүлээн авах саналтай.

**Ё.Энхтүвшин** – 1. Холбоо, интернэт, КаТВ-ийн дотор монтаж хийгдээгүй.

2. Техникийн нөхцөл авагдаагүй. Гадна дотор холбоожуулалтын ажил хийгдээгүй.

3. Хийгдсэн ажлуудын актыг бүрдүүлэх.

Эдгээр ажлыг гүйцэтгэж, үр дүнгээр улсын комиссоор хүлээн авах саналтай.

**И.Мянганбаяр** –1. 0.4 кв-ын кабелин трасс зөөсөн ажлын акт, зургийг үзүүлэх.

2. Цахилгааны щитийг тусгаарлаж өрөөнд хийх.

Дээрх ажлын биелэлтээр улсын комиссоор хүлээн авах саналтай.

**Б.Мөнхсайхан.**-1. Дуланы узелыг тусгаарлан хана, хаалга хийх

2. Хайтур ХХК, Сандэй ХХК-иудын хооронд хийгдсэн гэрээг эх хувиар нь үзлэх.

Дээрх асуудлыг шийдвэрлэсэний дараа улсын комиссоор авахад татгалзахгүй.

**Ц.Батцэнгэл** – 1.Сургалт хүмүүжлийн барилгын норм дүрмийн дагуу шаардлага хангасан байна.

2. Гадна тохижилт хийх

Дээрх асуудлыг шийдвэрлэсэний дараа улсын комиссоор авахад татгалзахгүй.

**Н.Шинэ-Оргил** – 1. Газрын гэрээ, гэрчилгээг нийслэлийн газрын албатай хийх.

2. Кадастрын зураг, CD-гээ НМХГ-т хувийг өгөх.

3. Хог хаягдалын гэрээ хийх.

4. Тохижилт ногоон байгууламжийг хийх.

Протоколын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

**Н.Сэмжид** – 1. Гадна тохижилт, гэрэлтүүлэг авто машины зогсоолын талбайг, зурагт тусгагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийж гүйцээх.

Улсын комиссоор байнгын ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

**Д.Жамсран** -1. Цахилгаан тоолуурыг өөрийн подвалын доод щитэнд угсрах.

2. Даралтын монометрийг баталгаажуулах.3. Халаалтын системд суурьлуулсан хэмжих хэрэгслийг баталгаажуулах.

3. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээг хувилж актанд хавсаргах.

Барилгын материалыг итгэмжлэгдсэн лаборатороор шинжлүүлсэн акт үзүүлэх.

Дээрх ажлуудыг гүйцэтгэсний дараа үзэж актаар хүлээж авах саналтай байна.

**С.Баатарсүрэн** – 1. Холбоо дохиоллын ажлын зураг хийлгүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг тавиулах.

2. Цахилгаан щитны өрөөний ханыг гүйцээж битүүлж хаалга үүдтэй болгох.

3. Галын усны шугмын иж бүрдлийг бүрэн болгож ГК таних тэмдгийг тавих.

4. Барилгын ажлын ил далд ажлын актуудыг тамга тэмдгээр баталгаажуулах

5. Барилгын гүйцэтгэгч нарын ажлын хариуцлагыг тусгай зөвшөөрөлтэй нь холбож тооцдог механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээрх ажлуудыг гүйцэтгэсний дараа үзэж актаар хүлээж авах саналтай байна.

**Ж.Ханипа** – 1. Тус объектод холбогдолтой бүх бичиг баримт, ил далд ажлын актууд, барилгын талбайн журнал, БУА-д ашигласан материалын паспорт, сертификат лабораторийн шинжилгээний үр дүнгүүд, ажлын гүйцэтгэлийн зураг, зургийн жагсаалтын дагуу иж бүрнээр нь инженер геологийн дүгнэлт далдлагдсан ажлын гэрэл зураг зэргийг архивын журам зааврын дагуу бүрдүүлж эх хувийг Үндэсний Төв Архивын сан хөмрөгт, хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.

Дээрх шаардлагыг биелүүлсэн тохиолдолд улсын комиссоор хүлээж авахад татгалзах зүйлгүй.

**Д.Оюунсүрэн** – 1. Захиалагчийн зүгээс тавих санал байхгүй.  
Хүлээн авах саналтай байна.

**Ш.Отгонхүү** - 1. Гүйцэтгэгч компаний зүгээс зураг төслийн байгууллагаас гаргасан зургийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэсэн. Захиалагч талын хөрөнгө мөнгөний боломжгүйгээс зоорийн дотор заслын ажил хийгдээгүй.

Улсын комисс ажиллаж барилгыг ашиглалтанд хүлээн авна уу.

**Ц.Баярбат** – 1.” Барилгын ажилд зохиогчийн хяналт хийх дүрэм” /БНБД 11-04-99/-ийн дагуу зохиогчийн нэгдсэн нэгдсэн дүгнэлт гаргуулах.

2. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийн хөтлөлтийг бүрэн гүйцэтгэх. /Барилгын улсын байцаагч, зураг төсөл зохиогч, захиалагчийн тавьсан шаардлага, зөвлөмжийг тэмдэглүүлж, биелэлт гаргасан байх/

3. Зоорийн давхарт хийгдэх заслын ажлыг бүрэн хийж дуусгах

4. Ариун цэврийн өрөөнд суултуурын хэсэгт халт хийж тусгаарлах

5. Барилгын өөрчлөлтийн болон гүйцэтгэлийн зураг төслийг зохиогчийн зүгээс баталгаажуулж баримт материалд хавсаргах


6. Барилгын тухай хуулийн 13.2-д заасан журмыг зөрчсөн “ЭкоГидроГео” ХХК. 13.5-д заасан журмыг зөрчсөн “Хайтур”ХХК-иудад хуулийн дагуу барилгын байцаагчийн зүгээс торгуулын арга хэмжээ тооцох

Комиссын гишүүдээс өгсөн санал дүгнэлтийн дагуу алдаа зөрчлийг арилгаж, шалгуулан гишүүд комиссын актанд гарын үсэг зурсаны дараа байнгын ашиглалтанд авах асуудлыг шийдвэрлэнэ. .

#### Шийдвэрлэсэн нь:


Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаварын дагуу захиалагч, гүйцэтгэгч нар ажиллаад биелэлтээ холбогдох гишүүдэд танилцуулсаны дараагаар Улсын комиссын актанд гарын зурж баталгаажуулан, барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулахаар шийдвэрлэв.

Протоколтой танилцсан :  
Улсын комиссын дарга



Ц.Баярбат

Протокол хөтөлсөн:  
Нарийн бичгийн дарга



Д.Доржсүрэн